

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Ус суваг” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайлан,
тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй
тайлан.

Аудитын код: ХӨА-2026/025/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/283

танай _____ -ны № _____ -т

“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.БАТСҮХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төвлөрсөн шугам сүлжээгээр 471.9 мянган м.куб ус олборлон, 338.6 мянган м.куб бохир усыг татан зайлуулах ажлыг хийж гүйцэтгэн, хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд усны алдагдлыг 4.9 хувиар бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 34.2 сая төгрөг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчиж 8.5 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрч 18.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 24.2 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 11 хоногоор хоцроож Төрийн аудитын

байгууллагад ирүүлсэн зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах 2 албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Бусад асуудлын хэсэг

“Хөвсгөл Ус Суваг” ХХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд усан хангамжийн эх үүсвэрийн 5 худаг, цэвэр усны II өргөлтийн насост станц, цэвэр усны төв болон салбар 55.5 км шугам сүлжээ, бохир усны төв болон салбар 44.7 км шугам сүлжээгээр дамжуулан төсөвт болон аж ахуйн нэгжийн 390 байгууллага, 63 орон сууцны 2,341 айл өрх, хувийн сууцтай 501 /гэр хорооллын/ айл өрхийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг үзүүлж байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17,186,741.37	2,467,226.30
1.1.2	Дансны авлага	174,840,352.96	387,943,860.24
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	70,027.47	1,086,094.91
1.1.6	Бараа материал	465,673,716.34	444,872,417.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	9,290,160.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	657,770,838.14	845,659,759.09
1.2.1	Үндсэн хөрөнгө	17,055,096,272.84	17,153,026,116.97
1.2.2	Биет бус хөрөнгө	3,626,440,681.80	3,621,943,761.90
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,681,536,954.64	20,774,969,878.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,339,307,792.78	21,620,629,637.96
2.1.1.1	Дансны өглөг	81,293,027.46	290,260,002.34
2.1.1.3	Татварын өр	74,451,756.26	191,113,128.54
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	99,608,250.79
2.1.1.6	Хүүний өглөг	544,149,712.46	544,149,712.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,000,000.00	32,398,596.01
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	632,662.12	10,694,665.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	704,527,158.30	1,168,224,355.14
2.1.2.1	Урт хугацаат зээл	12,765,185,465.58	13,065,247,833.36
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,765,185,465.58	13,065,247,833.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,469,712,623.88	14,233,472,188.50
2.3	Эздийн өмч	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.1	төрийн	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	657,840,694.47	657,840,694.47
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,986,308,416.24	7,624,360,498.24
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-2,020,434,611.48	-3,140,924,412.92
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,869,595,168.90	7,387,157,449.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,339,307,792.78	21,620,629,637.96

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,080,103,422.07	4,280,156,928.56
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,047,455,879.55	4,647,573,925.08
3	Нийт ашиг (алдагдал)	32,647,542.52	-367,416,996.52
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	347,428,104.10	448,273,629.28
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	6,336,000.62
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-300,062,367.78
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-314,780,561.58	-1,122,088,994.20
19	Орлогын татварын зардал	0.00	0.00

“Хөвсгөл Ус суваг ХХК-ийн” 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан.

20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-314,780,561.58	-1,122,088,994.20
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-314,780,561.58	-1,122,088,994.20
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-314,780,561.58	-1,122,088,994.20
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,834,858,652.54	-1,686,460,146.39	7,052,119,870.29
3	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,834,858,652.54	-1,686,460,146.39	7,052,119,870.29
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	-314,780,561.58	-314,780,561.58
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	-319,531,980.34	0.	-319,531,980.34
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,515,326,672.2	-2,001,240,707.97	6,417,807,328.37
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.	0.	1,599,192.76	1,599,192.76
11	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,515,326,672.2	-1,999,641,515.21	6,419,406,521.13
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	0.	-1,122,088,994.2	-1,122,088,994.2
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	401,783,406.	0.	401,783,406.
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,917,110,078.2	-3,121,730,509.41	5,699,100,932.93

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	4,673,535,513.84	4,510,563,324.92
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,178,036,016.62	3,917,567,562.57
1.1.6	Бусад мөнгөн орлого	495,499,497.22	592,995,762.35
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,674,206,250.21	4,227,557,096.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,773,132,309.73	2,124,229,206.56
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	497,551,318.65	276,050,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	582,238,871.45	286,132,413.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	918,623,123.50	897,496,365.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	146,563,517.00	168,042,528.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	523,418,311.15	357,680,917.86
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,041,600.00	11,171,110.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	224,637,198.73	106,754,555.47
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-670,736.37	283,006,228.69
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	131,296.24
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	131,296.24
2.2	Мөнгөн зарлагын дүн	2,000,000.00	297,857,040.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,000,000.00	297,857,040.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,000,000.00	-297,725,743.76
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,670,736.37	-14,719,515.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,857,477.74	17,186,741.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,186,741.37	2,467,226.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	2,267,594.3	2,240,619.0	26,975.3	98.8
2	НДШ	283,449.3	298,842.8	(15,393.5)	105.4
3	Албан томилолт	10,615.0	13,555.0	(2,940.0)	127.7
4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	34,410.0	46,470.5	(12,060.5)	135.0
5	Бичиг хэрэг	5,836.1	6,463.8	(627.7)	110.8
6	Хөдөлмөр хамгаалал	43,122.6	59,754.1	(16,631.5)	138.6
7	Нормын сүү	30,129.0	28,075.6	2,053.5	93.2
8	ХХХувцас, хэрэгсэл/ өвөл, зуны /	56,854.0	65,654.0	(8,800.0)	115.5
9	Түлш шатахуун	190,038.3	145,371.3	44,667.0	76.5
10	Сургалт	14,765.0	10,192.2	4,572.8	69.0
11	Үндсэн хөрөнгийн элэгдэл	673,590.5	877,155.9	(203,565.4)	130.2
12	Хөрөнгө оруулалтын ажил	673,590.5	88,440.1	585,150.4	13.1
13	Болзошгүй гамшиг	10,000.0	3,494.5	6,505.5	34.9
14	Ариутгал цэвэрлэгээ	25,774.5	13,207.9	12,566.6	51.2
15	Шинжилгээ	14,333.6	11,717.5	2,616.2	81.7
16	Цэвэрлэх байгууламжийн химийн бодис	14,216.2	0.0	14,216.2	-
17	Цахилгааны сэлбэг	19,918.9	19,200.0	718.9	96.4
18	Сантехникийн сэлбэг, багаж хэрэгсэл	25,748.5	25,700.0	48.5	99.8
19	УХЦБ салбарын урсгал засвар	2,770.0	2,820.0	(50.0)	101.8
20	ДХХУсны салбарын засвар	1,850.0	1,700.0	150.0	91.9
21	ЦХАТҮ-ний салбарын урс засвар	5,601.0	5,200.0	401.0	92.8
22	Машин механизмын сэлбэг	19,232.0	19,200.0	32.0	99.8

23	Цахилгаан	427,680.0	453,044.6	(25,364.6)	105.9
24	Халаалт	45,696.5	43,634.4	2,062.1	95.5
25	Түлээ	19,970.0	16,129.2	3,840.8	80.8
26	Нүүрс	322,035.0	328,573.0	(6,538.0)	102.0
27	НСАХ шагнал	30,150.0	31,034.4	(884.4)	102.9
28	Хөрөнгийн даатгал	5,500.0	5,500.0	-	100.0
29	Жолоочийн хариуцлагын даатгал	1,440.3	2,054.1	(613.8)	142.6
30	Газар ус ашигласны төлбөр	6,000.0	4,032.6	1,967.4	67.2
31	Үл хөдлөх хөрөнгийн татвар	44,935.3	14,529.9	30,405.4	32.3
32	Тээврийн хэрэгслийн татвар	1,479.8	976.3	503.5	66.0
33	Газрын төлбөр	8,885.4	6,872.2	2,013.2	77.3
34	Гадны байгууллагын хөлс	88,450.1	51,676.3	36,773.8	58.4
35	ТУЗ-ын зардал	62,375.0	54,421.9	7,953.1	87.2
36	Бусад зардал	11,760.0	11,912.7	(152.7)	101.3
37	Тусламж, тэтгэмж	107,189.7	94,957.9	12,231.8	88.6
38	Урт хугацаат зээлийн валютын ханшийн зөрүү	-	300,062.4	300,062.4	-
Зардал		4,933,395.9	5,402,245.9	(168,787.6)	109.5
Орлого		3,792,913.7	3,825,536.1	32,622.4	99.4
Ашиг ,алдагдал		(1,140,482.2)	(1,576,709.8)	(436,227.6)	138.2
Татаас санхүүжилт		290,000.0	454,620.8	164,620.8	156.8
Татаасын дараах ашиг ,алдагдал		(850,482.2)	(1,122,089.0)	(271,606.8)	131.9

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 18.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 24.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага, өр төлбөрийг барагуулах, копанийн үр ашгийг нэмэгдүүлэх төлөөр 3 зөвлөмжийг тус тус өгсөн.

Аудитаар Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 300.1 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Валютын ханшийн зөрүүнээс үүссэн 300.1 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдсэнийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг аудитын явцад санхүүгийн тайланд тусгаж залруулсан.

Аудитаар илрүүлсэн 42.7 сая төгрөгийн зөрчлөөс 18.5 сая төгрөг нь материалаг зөрчил бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн 18.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Тус байгууллагын албан хаагчид Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлэгт орж эмнэлгийн үйлчилгээ авсан байхад Нинж оюу ТББ-д 8.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд албан хаагчид Нинж оюу ТББ-аас эмнэлгийн зөвлөгөө, үйлчилгээ аваагүй бөгөөд анхан шатны баримт нотолгоогүй төсөв зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5 лугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалт болон Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Гүйцэтгэх захирал 2025.11.13-аас 2025.11.18-ны өдрийн хооронд шугам сүлжээний үнэ судлах, татан авах ажлаар Улаанбаатар хотруу албан томилолтоор явахдаа албан томилолтын хуудсанд ТУЗ-ийн даргын зөвшөөрсөн болон томилолт олгох гарын үсэг тамга тэмдгээр баталгаажаагүй байхад 0.5 сая төгрөгийн албан томилолтын зардлыг авсан байна. Энэ нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5 лугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн

20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалт болон Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

3. Үндэсний контент ХХК-д материалын үнэ гэж 10.0 сая төгрөгийг баримтад кино, контент хийлгэхээр гэрээ байгуулан шилжүүлсэн /08 дугаар сарын 28/ бөгөөд ямар нэгэн кино, контент хийлгээгүй бөгөөд авлага үүсгээгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5 лугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4."Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх"-ийг хориглоно гэсэн заалт болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дэрх зөрчлүүд нь Нягтлан бодо бүртгэлийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтуудтай нхийцэхгүй байгаа тул **төлбөрийн акт** тогтоож шийдвэрлэсэн.

Албан шаардлага.

Аудитаар 24.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тогтоосон. Үүнд:

1. Сургалтын болон бусад арга хэмжээний зардалад 14.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8."сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх, 12 дугаар зүйлийн 12.1.4."хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтуудтай нийцээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Ойн арга хэмжээнд гүйцэтгэх захирлын 2025 оны /08 дугаар сарын 28-ны өдөр/ А/55 дугаар тушаалаар 10.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус зардлыг Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд байрлах Ахмадын амралтын газарт албан хаагчдыг хүлээн авах үйл ажиллагаанд зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөрчил таслан зогсоох албан шаардлага өгсөн.

Хариуцлага тооцуулах албан шаардлага.

Хөвсгөл Ус суваг ХХК-иас 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа санхүүгийн тайлангийн аудит хийлгэхээр Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ хуулийн хугацааг 11 хоногоор хоцороож 2026.02.26-ны өдөр ирүүлсэн. Энэ нь Төвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8."Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалт болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогчид **хариуцлага тооцуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Гүйцэтгэх захирал, нягтлан бодогчид.

1. Өр төлбөртэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Богино хугацаат өр төлбөрийг өмнөх оноос 463.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 1,168.2 сая төгрөгийн өр төлбөрийг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үүссэн өр төлбөрийг барагдуулах, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллан үр ашиггүй зардал гаргахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: “Хөвсгөл Ус Суваг” ХХК нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Хуншагай-д.

3. Компанийн ашиг алдагдалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөөг 850.5 сая төгрөгөөр алдагдалтай баталсан бөгөөд тайлант онд 1,122.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн бизнес төлөвлөгөөг алдагдалгүй ажиллахаар тооцон төлөвлөж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	НББ-ийн тооцооллын алдаа	1	300,062.4	1	300,062.4			1
Дүн	1	300,062.4	1	300,062.4			1	300,062.4

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	-					1	-
Үр ашиггүй зардал гаргасан	2	24,205.0			1	24,205.0		
Анхан шатны баримтгүй, зардлыг зориулалт бусаар зарцуулсан	3	18,450.0	2	18,450.0				
НББ-ийн бодлогын баримт бичиггүй	1						1	
Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй	1						1	
Дүн	8	42,655.0	2	18,450.0	1	24,205.0	3	-

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил								
Худалдан авах ажиллагааны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй	1	357,500.0	-	-			1	357,500.0
Санхүүгийн аудитын зөрчил								
Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанаас 11 хоног хоцроосон	1				2	-		
Нийт дүн	2	357,500.0	-	-	2	-	1	357,500.0